



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: Мал эмнэлгийн үйлчилгээний үр дүн

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛ СУЛ, СУМАНД ЭМ БЭЛДМЭЛ, ВАКЦИН ТАРИЛГА ХАДГАЛАХ БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ДУТМАГААС МАЛД ЭРҮҮЛ ВАКЦИН ХИЙГДЭХГҮЙ ЭРСДЭЛ ҮҮСЧ БОЛЗОШГҮЙ БАЙНА.

Аудитын тайлан хүргүүлсэн: Аймгийн ИТХ, Мал эмнэлгийн газар, аймгийн ОНӨГ

Аудитын харилцан хамаарал:

“Мал эмнэлгийн үйлчилгээний үр дүн” сэдвийн аудитад гүйцэтгэлийн аудит хийснээр мал эмнэлгийн үйлчилгээ явуулж буй аж нэгж болон малын эм бэлдмэл, вакциныг хадгалах байр холбогдох хууль, дүрэм, журамд зөрчигдөж байгаа заалтууд болон тулгамдаж буй асуудлуудыг илрүүлэхэд оршино.

Үүнд: Аудитын сэдвийн хүрээнд шалтгаан, нөхцөл байдал, хүлээгдэж буй эрсдэлтэй асуудлыг тодорхойлох нь чухал юм.

Төлөвлөсөн эрсдэлтэй асуудлыг дурдвал:

- Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөөгүй байх.
- Мал эмнэлгийн үржлийн нэгжүүд нь стандартын дагуу орчин нөхцлийг бүрдүүлж ажиллаагүй байх.
- Мэргэжлийн малын эмчээр бүрэн хангагдаагүй байх.
- Улсын төсвөөс олгох мал эмнэлгийн вакцин, үйлчилгээний хөлсийг малын тоо толгойд үндэслэн оновчтой төсөвлөж батлуулаагүй байх.
- Орон нутгийн төсвөөс олгох мал эмнэлгийн вакцин, үйлчилгээний хөлсийг малын тоо толгойд үндэслэн оновчтой төсөвлөж батлуулаагүй байх.
- Улсын төсвөөс олгосон вакцин, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байх.
- Орон нутгийн төсвөөс олгосон вакцин, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байх.
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн нөхөн төлбөрийг хууль, журмын дагуу олгоогүй байх.
- Орон нутгийн төсвөөс олгосон нөхөн төлбөрийг хууль, журмын дагуу олгоогүй байх.
- Улс төсвөөс санхүүжүүлсэн нөхөн төлбөрөөс бусад зардлыг хууль, журмын дагуу олгоогүй байх.
- Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн нөхөн төлбөрөөс бусад зардлыг хууль, журмын дагуу олгоогүй байх.
- Лабораторийн шинжилгээний орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байх.
- Мал эмнэлгийн үржлийн нэгжүүдэд үйлчилгээний хөлсийг гэрээ болон гүйцэтгэлд үндэслэн тооцож олгоогүй байх.
- Мал эмнэлгийн үйлчилгээг явуулах тоног төхөөрөмж бүрэн хангагдаагүй байх.
- Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирүүлсэн тодорхойлолт шаардлага хангаагүй байх.
- Мал амьтны тархвар зүйн судалгааг хийгээгүй, мэдээллийн сан бүрдүүлээгүй байх.
- Мал амьтны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүйцэтгээгүй байх.
- Малыг эмийн зохистой хэрэглээг хангахад чиглэсэн сургалт сурталчилгааг хийгээгүй байх.

Аудитын сэдэвтэй холбогдуулж гарч болох шалтгаан, үр дагавар, эрсдэлийг тодорхойлсноор, аудитаар илэрч байгаа алдаа, зөрчилтэй асуудлуудад санал хүргүүлснээр байгууллагууд хоорондын уялдаа холбоо болон үйл ажиллагаанд тавих дотоод хяналт тус тус сайжирна гэж үзэж байна.

Аудитын зорилго, зорилтууд хамарсан хүрээ:

“Мал эмнэлгийн үйлчилгээний үр дүн” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ. Аудитын зорилтын хүрээнд:

- Мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулах бодлого, чиглэл бүрэн хангагдсан эсэх.
- Мал эмнэлгийн үйлчилгээнд олгож буй санхүүжилт болон орлогын бүрдүүлэлт, зарцуулалт үр дүнтэй байна эсэх.
- Мал эмнэлгийн үйлчилгээ үр өгөөжтэй эсэх
- Мал эмнэлгийн үйлчилгээнд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээнд аймгийн Мал эмнэлэг газар, сумдын мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 2023 үйл ажиллагаа болон үйлчилгээг хамруулж 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр аудитын тайланг нэгтгүүлэхээр аудитын дэд хөтөлбөр гарч аудитыг дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ удирдаж, аудитын явц, чанарын хяналт, арга зүйгээр зөвлөгөөг менежер Ж.Энхцоодол өгч, аудитыг ахлах аудитор П.Мөнхтуяа, Г.Намчинсүрэн, аудитор А.Сувдаа, Б.Энхтөр нар гүйцэтгэлээ.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл:

Аудит хийх хугацааны хувьд богино, холбогдох байгууллагуудаас аудиттай холбоотой тоон мэдээ, судалгаа, санал авахад малын эмч нар нь вакцин хийхээр багуудаар явсан, хөдөө томилолтоор ажиллаж байгаа зэргээс шалтгаалан аудитын хугацааны хувьд хойшлогдох эрсдэл үүсэх магадлалтай байсан.

Аудитын гол үр дүн:

- **МЭҮН-д нь стандартын дагуу орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллаагүй байна.**

Аймаг, сумын хэмжээнд 2023 онд 52 МЭҮН-д үйл ажиллагаагаа явуулж үүнээс өөрийн байртай 47, байргүй 5 газар байна.Аудитаар Булган сумын 2, Орхон сумын 4, Гурванбулаг сумын 4, Дашинчилэн сумын 3, Хутаг-Өндөр сумын 4, Сайхан сумын 4, Баян-агт сумын 2, Бүрэгхангай сумын 4, Бугат сумын 2 нийт 29 МЭҮН-дийн үйл ажиллагаа явуулж буй байр, эм бэлдмэл, вакцины хадгалалт хамгаалалтад аудит хийхэд “Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6.3¹, мал эмнэлгийн нэгжийн бүтэц, үйл ажиллагаа явуулах MNS5368:2018 стандартын 6 дугаар зүйлийн 6.1², 6 дугаар зүйлийн 6.1.2³, 6 дугаар зүйлийн 6.3⁴, 8 дугаар зүйлийн 8.2⁵, 8.4⁶, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А457 дугаар тушаалаар баталсан “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1⁷ гэсэн заалтуудыг дагаж мөрдөөгүй байна

- **МЭГ нь сум орон нутгийн удирдлага болон үйл ажиллагаа явуулж буй мал эмнэлгийн үржлийн нэгжүүдтэй гуравласан гэрээ байгуулж ажилладаг ч үйл ажиллагаанд нь тавих хяналт сул байна.**

2023 оны байдлаар 52 МЭҮН-ийн захирал, сумдын Засаг дарга, аймгийн МЭГ-ийн дарга нартай гуравласан гэрээг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр 1 жилийн хугацаатай байгуулсан. Тус гэрээнд захиалагч тал 8, гүйцэтгэгч талын эрх үүрэг, хариуцлагыг 18 төрлөөр тус тус хариуцаж биелэлтийг тооцож хамтран ажиллахаар гэрээ байгуулсан ч сумдын Засаг дарга нар урьдчилан сэргийлэх арга хэмжээний хийгдэх хугацааны захирамжаар үүрэг өгч ажиллаж байгаа ч МЭҮН-ийн хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

¹ мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахгүй байранд эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, эм, биобэлдмэл хадгалах, худалдах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах, хадгалахыг таслан зогсоох талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих,

² Барилга байгууламж,

³ Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах бөгөөд хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

⁴ Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж ажиллахын зэрэгцээ ариутгал, халдваргүйтгэл хийх багаж хэрэгсэл, халдваргүйтгэлийн бэлдмэлийн нөөцийг тусгай сав, агуулахад хадгална.

⁵тусгай шаардлага

⁶ Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж

⁷ Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дагуу ажлын байр, багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулна.

- **Мал эмнэлгийн үйлчилгээнд олгож буй санхүүжилт болон орлогын бүрдүүлэлт дутуу, зарцуулалтад тавих хяналт сул байна**

Улсын болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон ч нотлох баримт хангалтгүй 2,719.2 мянган төгрөгөөр илүү үйлчилгээний хөлс олгожээ. Улсын төсвөөс олгосон вакцин, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна. Үүнд:

МЭҮН-дэд олгосон вакцины хүрээнд үүссэн илрүүлэлт:

- Гурванбулаг сумын МЭТ нь “Шүүлт” ХХК-д мялзан, шүлхий, “Уянга яруу” ХХК-д шүлхий, “Дарий улаан” ХХК-д мялзан, бруцлёз, шүлхийн вакцинуудын тунгийн хэмжээг бичээгүй зарлагын баримт үйлдсэн,
- Хутаг-өндөр сумын “Уран тогоо таван эрдэнэ” ХХК вакцин авсан зарлагын баримт дутуу,
- 2023 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан вакцины шилийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 305 хайрцаг 9150 ш, 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 95 хайрцгийн 2850 ширхэг буюу нийт 12000 шил “Биокомбинатад” ТӨХХК-д хүргүүлсэн гэх боловч сумдаас вакцины шил хүлээн авч хүлээлгэн өгсөн акт үйлдэж баримтжуулж ажиллаагүй, бүртгэл хөтлөөгүй,
- тухайн онд нийт вакцины шил хэдийг хүлээж авах тооцоолол байхгүй, гэрээнд тусгаж ажилласан ч гэрээний 4 дүгээр зүйлийн 4.17^д гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,

2023 онд хүлээн авсан вакциныг 16 сумын МЭТ-т хүлээлгэн өгснөөр сумдын МЭҮН-дэд хуваарилалт хийсэн ч МЭТ нь МЭҮН-дэд хуваарилалт хийхтэй тооцоо нийлсэн акт үйлдэггүй, зарлагын баримтад вакцины литр болон м/тунгийн хэмжээ нэгж дүнг бичихгүй, илүү, дутуу бичиж өгсөн, МЭҮН-д нь вакцин өгсөн зарлагын баримтыг архивын нэгж болгоогүй задгай, зарлагын зарим нэг баримт дутуу, вакцин буцаасан, хүлээн авсан баримт үйлдээгүй зэрэг зөрчлүүд түүвэрлэлтэд хамрагдсан 9 сумын МЭТ болон 29 МЭҮН-дэд илэрч байна.

Гурванбулаг сумын “Уянга яруу” ХХК нь 2023 оны вакцины шилийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл цусан халдвартын 121, дотрын халдвартын 275, листериозийн 110 буюу нийт 506 ш вакцины шил хадгалж байгаа нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т⁸, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д⁹, 13 дугаар зүйлийн 13.7.¹⁰ гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчигдөж байна.

⁸ Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, хүн амыг зооноз өвчний эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавина.

⁹ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

¹⁰ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

Улсны төсвөөс 2023 онд 8 төрлийн вакцины үйлчилгээний хөлсөнд 1,171,832.5 мянган төгрөгийн санхүүжилт авч олгожээ.

МЭҮН-дэд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн хүрээнд үүссэн илрүүлэлт:

- Гурванбулаг сумын “Уянга яруу” ХХК, “Шүүлт” ХХК нь 2023 онд хийгдсэн шүлхийн вакциныг нэг өрхийн 25 үхэрт тарьснаар цувааг давхар үйлдэж 100.0,
- Хутаг-Өндөр сумын “Урантогоо таван эрдэнэ” ХХК нь шүлхийн вакциныг 214 малаар, бруцеллёзийн вакциныг 169 малаар тус тус зөрүүтэй цуваа үйлдэж нийт 161.6,
- “Эрэн цалам” ХХК нь шүлхийн вакциныг 404 малаар нэмж цуваа үйлдэж 161.6,
- Бүрэгхангай сумын “Бат-бүрэг” ХХК нь шүлхийн вакциныг 471 малаар, мялзангийн вакциныг 1683 малаар илүү хийснээр цуваа үйлдэж 609.1,
- Сайхан сумын “Баяннуур” ХХК 40.5, “Ундрах нуур” ХХК 17.8, Бугат сумын “Гал бүрэн” ХХК нь 604.3, “Номгон хан” ХХК 86.5 мянган төгрөгийн вакцины дүнгээс зөрүүтэй буюу илүү, дутуу зарцуулснаар тайлагнаж үйлчилгээний хөлсийг нийт 1,781.5 мянган төгрөгөөр илүү олгосон.
- Бугат сумын “Номгон хан” ХХК нь МЭТ-аас хүлээлгэж өгсөн вакцины дүн зарцуулсан дүнгээс 241.7 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Сайхан сумын “Угалз сайхан” ХХК 298.9,
- “Холбоо Баяннуур” ХХК 19.0,
- “Угалз хүрэмт” ХХК 20.6,
- “Ундрах нуур” ХХК 75.7,
- Дашинчилэн сумын “Баян-саруул” ХХК 145.3 мянган төгрөгөөр вакцины гүйцэтгэлийн тунг зөрүүтэй, тарилгын цувааны он, сар, өдөр бичигдээгүй, хорогдлын акт үйлдээгүй, хүлээлгэж өгсөн вакцины дүн зарцуулсан вакцины дүнгээс зөрүүтэй буюу илүү, дутуу зарцуулснаар тайлагнасан.

Гүйцэтгэлийн аудитад хамрагдсан сумдын 29 МЭҮН-ийн улс, орон нутгаас санхүүжсэн вакцины тарилгын акт, өрхийн цуваа, улсын байцаагчийн дүгнэлт, сумдын Засаг даргын тодорхойлолт зэргийг мал эмнэлгийн нэгдсэн системд оруулсан мэдээ, өрхийн өмнөх оны А дансанд бүртгэгдсэн малын тоо, нэг малд тарих вакцины тунгийн хэмжээ, гүйцэтгэлийн дүнтэй тулгахад өрхийн цуваанд малчны гарын үсэг, малчны тамга тэмдэг, утасны дугаар дутуу бичигдсэн, системд мэдээллийг бүрэн оруулаагүй, хянаж баталгаажуулаагүй, тайлбар хэсэгт тавиул малын тоо, нэмэгдсэн хасагдсан дүн бичигдээгүй, малын тоог зөрүүтэй, давхардуулж бичиж үйлчилгээний хөлсийг илүү тооцож авсан, багийн Засаг даргын тодорхойлолт гаргаагүй, хүлээж авсан вакцины дүн зарцуулсан дүнгээс зөрүүтэй зарцуулснаар тайлагнаж Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6.11-д¹¹, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д¹², 13 дугаар зүйлийн 6-д¹³ гэсэн бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

- **Орон нутгийн төсвөөс 4 төрлийн 236,037.6 мянган төгрөгийн вакцины санхүүжилт авсан ч хийгдээгүй вакцины үнийг төсөвт төвлөрүүлээгүй байна.**

МЭҮН-д олгосон вакцины үйлчилгээний хөлсийг аймгийн ИТХ-д санал хүргүүлж ажиллаагүй өнөөг хүртэл Монгол улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “өвчний жагсаалт”-д тусгагдсан малын урьдчилан сэргийлэх арга хэмжээний 1 малд ногдох үйлчилгээний хөлсийг Сангийн сайд, ХХААХҮ-ийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 118-А201 дүгээр хамтарсан тушаалын хавсралтад тусгагдсан үнийн

¹¹ мал эмнэлгийн үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэлд удирдамжийн дагуу хяналт шалгалт хийх

¹² Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

¹³ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

тарифаар тооцож ажилласан нь Мал амьтны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5¹⁴ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн төсвөөс сургалтын зардалд 7000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч тус сургалтын зардлыг Монголын Хэрэглэгчийн Удирдлагын академийн Төрийн банкны 380000022590 тоот данс руу шилжүүлэхдээ сургалтын гэрээ хийгээгүй, төсвийн тооцоолол, ямар сургалтад хэдэн хүн хамрагдсан, сургалтын хөтөлбөр, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажиллаагүй, захирамжийн хавсралтаар баталсан ажилчид яваагүй, МЭҮН-д ажилладаггүй иргэнийг авч явсан, зардлын төсөв гүйцэтгэл байхгүй, нэг хүний зардлыг 700.0 мянган төгрөгөөр тооцсон ч албан хаагчдаас нэмж 2464.0 мянган төгрөгийг илүү тооцсон, албан бус хүний 350.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрч байна.

- **Улс болон орон нутгийн төсвөөс нөхөн олговор олгоогүй байна.**

Оношлогдсон өвчний хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17.2.1¹⁵-д заасны дагуу хорио цээрийн дэглэм тогтоож, МЭҮН-тэй хамтран өвчилсөн малд эмчилгээ хийж ажилласан бөгөөд зайлшгүй шаардлагаар устгал хийгдээгүйтэй холбоотой байна.

- **Өөрийн орлогыг 9,050.0 мянган төгрөг төлөвлөснөөс 6.283.0 мянган төгрөг буюу 65 хувиар дутуу, ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмж ашиглаж байна.**

Булган аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны төсвийн төсөлд лабораторийн орлогыг 9,050.0 мянган төгрөгийн төсвийн саналыг өгч гүйцэтгэлээр 2,767.0 мянган төгрөгийн орлого орсон бол өмнөх онд 743.6 мянган төгрөгийн орлоготой харьцуулахад өмнөх оноос 2023.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна.

Лабораторийн оношилгоо, шинжилгээний орлогыг 2023 онд 9,050.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч төлөвлөгөөнөөс 6,283.0 мянган төгрөгөөр дутуу биелсэн байна.

ОНХС-аас 2023 онд 16 сум 1 тосгоны хүрээнд мал эмнэлгийн тоног төхөөрөмж, бусад үйл ажиллагаанд зарцуулахаар 15 сум, 1 тосгон нь 31 арга хэмжээ 610,043.0 мянган төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 315,710.0 мянган төгрөгийн 21 арга хэмжээ хийгдэж, 268,004.0 мянган төгрөгийн 10 арга хэмжээ нь хийгдээгүй байна.

Өмнөх онуудад ашиглагдахгүй олон жил болсон мал угаалгын ванн бусад үндсэн хөрөнгө нь сумын төвийн айлын хашаанд байгаа нь эзэнгүйдэх эрсдэл үүсэж байгаа тул цаашид ашиглах боломжтой, боломжгүйг тогтоож, шийдвэрлэн ажиллах шаардлагатай байна

- **Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлт дутуу хэрэгжсэн байна.**

Хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг товч танилцуулсан тухай тайланд зөрчил арилгуулах тухай 36 аж ахуй нэгжид албан шаардлага хүргүүлсэн гэж тайланд тайлагнасан боловч тус албан шаардлагыг одоо хүртэл холбогдох аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж ажиллаагүй байна.

Тус газарт аймгийн СХДА-ын албаас МЭГ-ын 2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалтыг 2023 оны 10 сард хийж шалгалтаар “Бараа материалд агуулахын бүртгэлийг тухай бүр хөтөлж үлдэгдлийг баталгаажуулах”, “Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг МЭҮН-тэй хагас, бүтэн жилээр тооцоо нийлж өглөг, авлагыг санхүүгийн тайланд бүрэн тусгах”, “Санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийх”, “Өмнөх шалгалтаар

¹⁴ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын саналыг үндэслэн аймаг,

нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

¹⁵ халдварт өвчний тархалт нэг сумын нутаг дэвсгэрийг хамарсан, эсхүл халдварт өвчний голомтыг нэгтгэх нөхцөл үүсээгүй бол мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн сумын Засаг дарга

илэрсэн зөрчлүүд арилахгүй байгаад анхаарч, давтан гаргахгүй таслан зогсоох талаар тодорхой ажил зохион байгуулах” гэсэн 4 чиглэлийн зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан хүргүүлж ажилласан ч гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлөөс үзэхэд шалгалтаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Аудитын дүгнэлт:

Аудитаар нийт 2,932.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 4.1 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 1,167.7 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 1,760.9 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын дүн, тайланд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 82 хувиар дүгнүүлсэн ч хэрэгжилтийг үр дүн, ач холбогдлоор, хэмжиж болохуйцаар дүгнэж тайлагнаагүй байна,
- МЭҮН-д нь вакцин эм бэлдмэл хадгалах байр, хөргөгч хөлдөөгчгүй,
- Улсын төсөв, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг тооцохдоо нотлох баримтад үндэслээгүй 2,852.7 мянган төгрөгөөр илүү үйлчилгээний хөлс олгожээ,
- Хийгдээгүй 136.5 мянган төгрөгийн вакцины үнийг төсөвт төвлөрүүлээгүй,
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг аймгийн ИТХ-д санал хүргүүлж нэмэгдүүлээгүй,
- МЭҮН-дийн 4.1 хувь нь шаардлага хангаагүй мал эмнэлгийн гэрчилгээ олгосон,
- Мал амьтны тархвар зүйн судалгааг 20 жилээр хийсэн ч вакцинд хамрагдах малчин, мал бүхий иргэдийг mahis.gov.mn нэгдсэн системд оновчтой төлөвлөөгүй,
- МЭҮН-дийн гэрээг бодиттой үнэлээгүй,
- Лабораторийн дээж хүлээн авах журналыг бүрэн хөтлөөгүй,
- Бугат сумын ЗДТГ нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй,
- МЭҮН-ийн вакцинжуулалтын цуваа дээр малчнаар гарын үсэг зуруулаагүй, тамга тэмдэггүй боловч багын Засаг даргын тодорхойлолтгүй,
- Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг 78 хувийн гүйцэтгэлтэй мэдээлсэн,
- Дотоод хяналтын төлөвлөгөө батлуулаагүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд биелэлт тооцсон,
- Дотоод хяналт болон бусад хяналт шалгалтаар өгсөн албан даалгавар зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаагүй, мал эмнэлгийн үйлчилгээ болон үйл ажиллагаанд тавих хяналт сул байна гэж дүгнэлээ.

Аудитын зөвлөмж:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИХТ-ын дарга Д.Эрдэнэбат танаа:

- МЭГ-аас Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх саналыг үндэслэн баталж ажиллах.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга танаа:

- Сумдын ЗДТГ-т бүртгэлтэй олон жил ашиглагдахгүй, айлын хашаанд байгаа мал угаалгын ванн бусад тоног төхөөрөмжийг цаашид ашиглах боломжтой, боломжгүйг тогтоож, шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллах.

Аймгийн МЭГ-ын дарга Г.Одсүрэн танаа:

- МЭҮН-тэй хийсэн гэрээний биелэлтийн тайланг нэг загвараар адил болгон гэрээний үнэлгээг хүлээгдэж буй гүйцэтгэл, үйлчилгээний хөлс, дараагийн гэрээнд нөлөөлөх уялдаа холбоог ханган ажиллах.
- Сумдын МЭТ болон МЭҮН-дэд эмийн зохистой хэрэглээний сургалт хийх төлөвлөгөөг боловсруулан ажиллах.
- Мал эмнэлгийн лабораторийн <https://vetlab.shinjilgee.mn/> программ, дээж хүлээн авах бүртгэл журналыг үнэн зөв хөтлөх.
- МЭҮН-дийг шилэн дансанд бүртгэлжүүлж, хугацаанд нь мэдээллийг мэдээлж ажиллах.